



БАЯНХОНГОР АЙМАГ
БААЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 18 өдөр

Дугаар АНБ

Баянсайр

Мал амьтны гоц халдварт “Шүлхий”
өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаалжуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 1.8, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйл, Мал эмнэлгийн Ерөнхий газрын 2022 оны А/77 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын А/249 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Мал амьтны гоц халдварт “Шүлхий” өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд сумын нутаг дэвсгэрт байгаа нийт үхрийг хамруулан зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Мал амьтны гоц халдварт “Шүлхий” өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зураглал маршрутын дагуу технологит хугацаанд шуурхай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг, “Монгол –Овоо” ХХК (Ч.Дэлгэрмаа), “Буянт хөөвөр” ХХК (Ж.Хатантуул), мэргэжил арга зүй, заавар зөвлөмжөөр ханган, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга Улсын байцаагч (Л.Цэцгээ) нарт даалгасугай.

4. Вакцины дархлаа тогтоох 28 хоногийн хугацаанд малчдын нүүдэл, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасаг (Л.Цэцгээ), Цагдаагийн хэсэг (Б.Өсөхбаяр), багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

642101355

5. Дархлаажуулалтын ажилд шаардагдах төсвийг зориулалтын дагуу зарцуулж, хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Гэрэлмөнх), Мал эмнэлгийн тасаг (Л.Цэцгээ)-нарт хариуцуулсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч, сумын Онцгой комиссын шуурхай штабын дарга (Б.Бямбаням)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ЗНХТӨР



Сумын Засаг даргыноны
дугаар сарынны өдрийн.....
дугаар захирамжийн хавсралт

**МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**

1 дүгээр ажлын хэсэг:

Ажлын хэсгийн ахлагч : Б.Наранбаатар –Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга- Л.Цэцгээ- Мал эмнэлгийн тасгийн дарга улсын
байцаагч

Гишүүд: Ч.Дэлгэрмаа –“Монгол Овоо” ХХК-ны малын их эмч

П.Батгэрэл -1 дүгээр багийн Засаг дарга

Д.Баттөр -5 дугаар багийн Засаг дарга

Г.Баянжаргал -6 дугаар багийн Засаг дарга

Б.Хүрэлбаатар -7 дугаар багийн Засаг дарга

Ж.Төрмөнх –“Монгол-Овоо” ХХК-ны жолооч

Н.Алтангэрэл - Тамгын газрын ажилтан

Т.Батсүх –Тамгын газрын нярав

2 дугаар ажлын хэсэг:

Ажлын хэсгийн ахлагч : Б.Бямбаням-Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга- Л.Цэцгээ-Мал эмнэлгийн тасгийн дарга, улсын
байцаагч

Гишүүд: Д.Баттөр – “Буянт хөөвөр” ХХК-ны малын их эмч

Ч.Дэлгэрмаа –“Буянт хөөвөр” ХХК-ны захирал

Т.Билэггэндэн -2 дугаар багийн Засаг дарга

Ж.Солонго-3 дугаар багийн Засаг дарга

П.Мөнхжаргал -4 дүгээр багийн Засаг дарга

Ж.Төрмөнх –“Монгол-Овоо” ХХК-ны жолооч

Ч.Батдорж – “Буянт хөөвөр” ХХК-ны ажилтан

Н.Алтангэрэл - Тамгын газрын ажилтан